



СЭЛЭНГЭ АЙМАГ
ОРХОН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 08 өдөр

Дугаар А/51

Нарт

Тариалангийн талбай, өвөлжөөний газрыг
малын хөлөөс чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, Тариалангийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1, Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2, 54 дүгээр зүйлийн 54.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тариалангийн тухай хуулийг сурталчлах, малчид тариаланчдын харилцан уялдаа холбоог сайжруулах, тэдгээртэй холбогдож гарсан зөрчлийг шийдвэрлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч :	Засаг даргын орлогч
Гишүүдэд:	ХАА-н тасгийн агрономич
	1-р багийн Засаг дарга
	2-р багийн Засаг дарга
	БОХУБайцаагч
	Газрын даамал
	Хэсгийн цагдаа

2. Тариалангийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган 2023 оны тариалалт эхэлж байгаатай холбогдуулан 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн 10 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд үр тариа, төмс хүнсний ногооны талбай, өвөлжөө, хаваржааны бэлчээрийг малын хөлөөс чөлөөлсүгэй.

3. Үр тариа, төмс хүнсний ногооны талбайн ойр өвөлжиж, хаваржиж байгаа малчин, мал бүхий иргэд, айл өрхүүдэд 5 сарын 10-ны өдрөөс 10 сарын 15-ныг хүртэлх хугацаанд тариалангийн газар өвөлжөө, хаваржааны газрыг малын хөлөөс чөлөөлөх тухай албан мэдэгдэл тараах, заасан хугацаанд газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан газарт нүүлгэн шилжүүлэх ажлыг багийн хэмжээнд зохион байгуулан ажиллахыг 1-р багийн Засаг дарга, 2-р багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэд болон малчин, мал бүхий иргэдэд тариалангийн тухай хууль, ХХААХҮ сайд, Хууль зүйн дотоод хэргийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны 8 сарын 20-ны өдрийн А-136, А-158, А-210 дугаар тушаалын хавсралт тариалангийн талбайд мал тэжээвэр амьтан орсны улмаас тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчид учруулсан хохирлыг тооцох аргачлалын талаар сурталчлан танилцуулж хохирол

гарсан тохиолдолд тус аргачлалын дагуу тооцон ажиллахыг ажлын хэсэгт даалгасугай.

5. Өөрийн өмчийн мал сүрэг, тэжээвэр амьтдыг үр тариа, төмс хүнсний ногооны талбайд оруулахгүй байх талаар анхаарч өдрийн цагаар хариулгатай байлгах шөнийн цагаар хашиж байхыг малчид мал бүхий иргэдэд даалгасугай.

6. Тариалангийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган тариалалт, уриншлалт, ургац хураалтын мэдээг графикт хугацаанд нь сумын ХАА-н тасгийн холбогдох мэргэжилтэнд мэдээлэх, plant.gov.mn цахим программд өөрийн эзэмшлийн тариалангийн талбайг бүртгэлд оруулах тариалалт ургац хураалтын мэдээг программд шивэх, өөрийн эзэмшлийн талбайгаа тариалангийн талбайн түүх хөтлөх, өөрийн эзэмшлийн талбай, тариалсан үр тариа, төмс хүнсний ногоог мал тэжээвэр амьтдаас хамгаалах талаар хуулиар зөвшөөрөгдсөн тодорхой арга хэмжээг авч, сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан малын бэлчээр болон төв суурин газрын ойролцоох тариалангийн талбайг хашаажуулж хамгаалах, талбайн харуул манаачыг байнгын ажиллагаатай байлгаж, унаа холбооны хэрэгслээр ханган холбогдох хууль тогтоомжийн дагуу үүрэгжүүлж ажиллуулахыг газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдэд үүрэг болгосугай.

7. Тус захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч, БОХУБайцаагч нарт үүрэг болгосугай.



Г. БАТ-ОРХОН